# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 29 өдөр Дугаар А/459 Улаанбаатар хот

## Нийслэлийн хүүхдийн 267 дугаар цэцэрлэгийн хөрөнгө данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Машин, тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 390,000.0 (гурван зуун ерэн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Нийслэлийн хүүхдийн 267 дугаар цэцэрлэг (Б.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн хүүхдийн 267 дугаар цэцэрлэг (Б.Байгалмаа)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА В.ОЮУМАА

1/25011202

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А/453 дугаар тушаалын хавсралт

# Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн хүүхдийн 267 дугаар цэцэрлэг

| № | Хөрөнгийн нэр | Марк дугаар | Ашиглалтад авсан он | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэлийн анхны үнэ | | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Дансны нэр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Нэгж үнэ | Нийт үнэ | | | шилжүүлэх данс | бүртгэх данс |
| 1 | Савны цуглуулга | Никель | 2020 | дунд | ш | 1 | 290,000.00 | 290,000.00 | 290,000.00 | - | Машин тоног төхөөрөмж | Бусад хангамжийн материал |
| 2 | Хоол зөөх зориулалттай сав | Никель | 2020 | дунд | ш | 1 | 75,000.00 | 75,000.00 | 75,000.00 | - | Машин тоног төхөөрөмж | Бусад хангамжийн материал |
| 3 | Данх | Никель | 2020 | дунд | ш | 1 | 25,000.00 | 25,000.00 | 25,000.00 | - | Машин тоног төхөөрөмж | Бусад хангамжийн материал |
| Шилжүүлэх хөрөнгийн дүн | | | | | | 3 | | 390,000.00 | 390,000.00 | - | - | - |